

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2026 БАГА СУНГАА СОРИЛ

Хувилбар-С

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг дуустал уншиж ойлгоорой.
3. 1-13 сорилыг эхийн утга санаатай холбож ажиллаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

ӨЭЛҮН ЭХ

"Алив охин минь, энэ утасны ээдрээг гаргаад орхи!" гэж Өэлүн эх хэлээд, ширдэг дээр овоолсон торгон утасны зүг заалаа. Бөртэ хатан ойрдоо хийгээгүй ажилд баахан тээршээвч утсыг өвөр дээрээ аваад, махлаг хуруугаараа сэмлэн ялгах зуур өөр лүүгээ ширтэн буй хадам эхийн харцыг мэдэрч, түгшин эмээж суужээ.

"Иймэрхүү ажлаас сүрхий төсөөрөх нь дээ, чи минь" гэж эх хэлснээ, "Чиний буруу алга. Эзэн эр чинь өнөө Хар тэргүүтний хаан. Тийм болохоор чи утас ялгах биш, ширэлдэн холбогдсон тэр олон ихсийн үг санааг ялган тунгаах илүү бэрх ажилтай хүн шүү дээ" гэж үгээ залгахад нь Бөртэ аг чиг сууж, Тэмүүжинтэй дэр нэгтгэхээс өмнө энэ хатуу чанд эхийн зовон зүдэж яваа сургийг сонсож, аймсан байснаа дурсана. Есүхэй баатрын нас нөгчсөнийг дуулаад, эцэг Дэй сэцэн нь охиныхоо хувь тавиланд хэрхэн түгшиж байгааг Бөртэ гадарласан. Нэгэнтээ Тэмүүжиний гэрт очно гэдгээ мэдэж байсан болохоор охин өөрөө ч Есүхэйн хөвгүүдийн сургийг шимтэн чагнадаг байжээ.

...Одоо Бөртэгийн дэргэд суугаа зөөлөн харцтай, наснаасаа эрт өтөлсөн буурал эмэгтэйд тэр үеийн Өэлүний өнгө жавхаа бараг алга болсон ч сөргөхийн аргагүй сургамжтай үгс нь хэвээрээ, илүү ч гүн утгатай болсон ажаам.

"Эдэрсэн утсыг тэвчээрээр эвт нь оруулахаас бус, хүчээр хийж хэрхэвч үл болох. Энэ бол хатдын залуу байхаасаа л сурах ажил. Хэрвээ үр хөвгүүд, эзэн эрээ өөд татсугай хэмээвэл чухам эдэрсэн утсыг салгах мэт хичээвэл зохилтой. Ганц хайрлалтай нь үүнийг санах эхнэр даанч ховор. Харин чи өөр хүн. Хөвгүүдийн чинь зан ааль надад их л сайшаагдана. Өгөөдэй, Толуй хоёр төвшин болоод нягт чамбай. Гэвч...чи, Тэмүүжин хүүг минь баахан мартсан мэт..." Энэ үгэнд Бөртэ ичих, цочих хосолж эхийн зүг харвал Өэлүн инээмсэглэсэнгүй харц нь сүрхий шаардах өнгөтэй. Бөртэ толгой бөхийж:

"Эх өршөө. Хүү тань өнөө их бага олон аймгийг хамтатган захирсан хаан бус уу. Түүнийг сурган залах гэгч яахан санаанд багтана" гэвэл, Өэлүн шүүрс алдаад: "Чухамдаа гэрийн гаднах үйл бидэнд хамаагүй. Гэвч дотоод, гадаад ажил цөм нийлж, нэгэн айлын үйлс болдог. Айл гэрээс үл хамаарах төр гэж үгүй. Би чамайг эрх мэдэлдээ олтгойрох хүн гэж ер үл бодном. Гагцхүү эзэн эрийнхээ ааш занг хөвгүүдийнхээсээ багагүй ажиж байгаасай гэж хүснэ. Эртнээс сургаснаар арга билиг гэгч энэ бөлгөө. Арга гэж нар болой. Нар гэгч эр. Эрийн чанар хатууд түшжээ. Тэгвэл билиг гэгч сар буюу эм. Эмийн чанар зөөлнийг эрхэмлэнэ. Мэргэд гэдэг бол нар сарыг хамтатгасан хурмаст гэвээс болно" гэв...











Т. Мандир

1. Өэлүн эх Бөртэ хатанд хандан "Утасны ээдрээг гаргаад орхи" гэж хэлсний учир юу вэ?
 - A. Ураг удмын ахан дүүс нь хоорондоо эвлэхгүй их харгалдаантай байсан учраас
 - B. Их хааны эх болон хатдын дунд зөрчил маргаан байнга гараад байсан учраас
 - C. Оёж шидэх үйл үйлдэхэд утас нь байнга эдэрч орооцолдоод болохгүй байсан учраас
 - D. Үр хөвгүүд, эзэн эрээ эвтэй, хүчтэй байлгах арга ухааныг сургамжилья гэсэн учраас
 - E. Бөртэ хатан ойрдоо огт ажил хийхгүй цааргалж, хойшлуулаад байдаг болсноос
2. Аль өгүүлбэр нь Бөртэ хатан Өэлүн эхийн зүдэж буйг мэдсэн цаг хугацааг илэрхийлж байна вэ?

- A. Зөөлөн харцтай, наснаасаа эрт өтөлсөн буурал эмэгтэй.
 - B. Хатан ойрдоо хийгээгүй ажилд баахан тээршээсэн.
 - C. Нэгэнтээ, Тэмүүжиний гэрт очно гэдгээ мэдэж байсан.
 - D. Энэ бол хатдын залуу байхаасаа л сурах ажил.
 - E. Тэмүүжинтэй дэр нэгтгэхээс өмнө сургийг сонсож байсан.
3. Үгийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1. ээдрээ	a. чимээ аниргүй			
2. аг чиг	b. бэрхшээх, төвөгшөөх			
3. тээршээх	c. ширэлдэж орооцолдох			
4. аймсах	d. үймэрч уймрах			
A. 1c,2b,3a,4d	B. 1a,2b,3c,4d	C. 1c,2a,3b,4d	D. 1c,2d,3b,4a	E. 1d,2b,3a,4c
 4. Эхийн сэдвийг сонгоорой.
 - A. Эх хүний эрхэм нандин сургаалын тухай
 - B. Чингис хаан олон аймгийг нэгтгэсэн тухай
 - C. Бөртэ хатны ухаажин, урамшиж буй тухай
 - D. Эдэрсэн утасны орооцолдоог гаргах тухай
 - E. Их Монгол улсын хүчирхэгжсэн тухай
 5. Эхийн гол санаанд тохирох хэлц аль нь вэ?
 - A. Ёсчлон явбал хурчлан бууна
 - B. Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй
 - C. Бие шулуун бол сүүдэр буруугүй
 - D. Сэтгэл сайхан бол өнгө нь сайхан
 - E. Ёсыг ёроолоос нь, учрыг угаас нь
 6. Зохиогчийн хэлэх гэсэн санааг илэрхийлсэн өгүүлбэр аль нь вэ?
 - A. Чухамдаа гэрийн гаднах үйл бидэнд хамаагүй.
 - B. Айл гэрээс үл хамаарах төр гэж үгүй.
 - C. Дотоод, гадаад ажил цөм нийлж, нэгэн айлын үйлс болдог.
 - D. Чухам эдэрсэн утсыг салгах мэт хичээвэл зохилтой.
 - E. Би чамайг эрх мэдэлдээ олтгойрох хүн гэж ер үл бодном.
 7. "Хэрвээ үр хөвгүүд, эзэн эрээ өөд татсугай хэмээвэл чухам эдэрсэн утсыг салгах мэт хичээвэл зохилтой. Ганц хайрлалтай нь үүнийг санах эхнэр даанч ховор. Харин чи өөр хүн." гэсэн өгүүлбэрт байгаа эсрэгцүүлэн холбох үг ямар үүргээр орсон бэ?
 - A. Хөвгүүдээ төвшин болоод нягт нямбай болгож хүмүүжүүлснийг тодруулах
 - B. Бөртэ бусад хатдаас илүү тэвчээртэйг тодруулах
 - C. Эдэрсэн утсыг салгах мэт хичээдэг ухаалаг болохыг тодруулах
 - D. Үр хүүхдээ зөв үйлд сургаж байгааг тодруулах
 - E. Эрх мэдэлдээ олтгойрдоггүй шинжийг тодруулах
 8. "...Одоо Бөртэгийн дэргэд суугаа зөөлөн харцтай, наснаасаа эрт өтөлсөн буурал эмэгтэйд тэр үеийн Өэлүний өнгө жавхаа бараг алга болсон ч сөргөхийн аргагүй сургамжтай үгс нь хэвээрээ, илүү ч гүн утгатай болсон ажаам" гэсэн хэсгээс зохиогчийн үнэлгээ дүгнэлтийг илэрхийлэх хамгийн чухал үг хэллэгийг олоорой.
 - A. наснаас эрт өтөлсөн буурал эмэгтэй
 - B. өнгө жавхаа алга болсон ч сөргөхийн аргагүй
 - C. зөөлөн харцтай, буурал эмэгтэй
 - D. үгс нь хэвээрээ, илүү ч гүн утгатай болсон
 - E. сургамжтай үгс нь хэвээрээ
 9. "Эдэрсэн утас" гэсэн дүрслэлийн далд утгад тохирох нь аль вэ?
 - A. Хэрвээ үр хөвгүүд, эзэн эрээ өөд татсугай хэмээвэл чухам эдэрсэн утсыг салгах мэт хичээвэл зохилтой.

- В. Энэ бол хатдын залуу байхаасаа л сурах ажил.
 С. Утас ялгах биш, ширэлдэн холбогдсон ихсийн үг санааг ялган тунгаах
 D. Мэргэд гэдэг бол нар сарыг хамтатгасан хурмаст гэвээс болно.
 E. Өгөөдэй, Толуй хоёр төвшин болоод нягт чамбай.
10. "...Өөр лүүгээ ширтэн буй хадам эхийн харцыг мэдэрч, **түгшин эмээж** суужээ" гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг аль хэлцээр солин найруулбал тохирох вэ?
 A. зүрх догдлох В. айхаа арьсанд боох С. зүрх амаар гарах
 D. зүрх алдах E. зүрх гаргах
11. Төгсгөлийн цогцолборт байгаа үг хэллэгийн дарааллыг ажиглаад цэгийн оронд тохирох үгийг сонгоорой.
 их бага, эрх мэдэл, дотоод гадаад, айл гэр, нар сар, ааш зан,
- A. хувь тавилан
 B. өнгө жавхаа
 C. арга билиг
 D. хатуу чанд
 E. үр хөвгүүд
12. Өгүүлбэрт онцолсон баймж бүтээвэртэй ойролцоо утгатай нөхцөлийг олоорой.
 Өзлүний өнгө жавхаа бараг алга болсон ч сөргөхийн аргагүй сургамжтай үгс нь хэвээрээ.
 A. -соор B. -ж C. -оод D. -н E. -вч
13. "Эдэрсэн утсыг тэвчээрээр эвт нь оруулахаас бус, хүчээр хийж хэрхэвч үл болох. Энэ бол хатдын залуу байхаасаа л сурах ажил. Хэрвээ үр хөвгүүд, эзэн эрээ өөд татсугай хэмээвэл чухам эдэрсэн утсыг салгах мэт хичээвэл зохилтой" гэсэн хэсэгт ямар өнгө аяс илэрч байна вэ?
 A. халагласан B. хөөрхийлсэн C. сургамжилсан D. биширсэн E. бахархсан
14. "Тэмүүжин, Бөртэ тэргүүтэй хөвгүүд, бэрс, шадар, баатруудыг үтэр цуглуул..." гэсэн өгүүлбэрт цуваа цэг хэрэглэсний учир юу вэ?
 A. Зохиолын том бүлэг, их хэсгийг орхисон тул мөргөсөн цэг хэрэглэсэн.
 B. Өгүүлбэрийн дунд хэлэлгүй орхисон үгийн оронд цуваа цэг хэрэглэсэн.
 C. Мэгдэж түгдэрсэн тул цуваа цэг хэрэглэсэн.
 D. Эш татсан зүйлийн энд тэндээс орхисон тул цуваа цэг хэрэглэсэн.
 E. Үг, өгүүлбэр төгссөн боловч зохиогч санаагаа бүрэн гаргаж чадаагүй дутуу орхисон тул цуваа цэг хэрэглэсэн.
15. Ойролцоо утгатай үг бүхий хэлцийг олоорой.
 A. Баруун чихээр ороод, зүүн чихээр гарах
 B. Надад инээд, чамд ханиад
 C. Сайн эр урдаа шархтай, муу эр хойноо шархтай
 D. Гэмтэйгээс гэтэлгэсэн, гайтайгаас гаргасан
 E. Торгон дээлтэй хүнийг бөөлжихөд өрмөг дээлтэй хүн ч жигшинэ
16. Доод найруулгын зэрэг бүхий өгүүлбэрийг сонгоорой.
 A. Таны хэлсэн мэргэн үг миний толгойд хадаатай.
 B. Мөрөн дээрх бөндгөрөө мэдэж хэлээрэй.
 C. Их багштаны тэргүүнд эрдэм гэгч ойгүй ээ.
 D. Хүний толгойд олон юм бодогддог.
 E. Тэргүүтнийг дэлдийлгэж, толгойтныг бөхийлгөх
17. "ч" бүтээвэр нь зэрэгцүүлэн онцлох утга ялгаж байгаа хэсгийг олоорой.
 A. Бид эндээс гарч, тэднийг дагууллаа.
 B. Малч хүний гярхай чанар өөр юм.
 C. Багш ч ирлээ, бид ч цуглалаа.
 D. Чихэр амттай боловч жингээр идэж болохгүй.

- E. Яавч засрахгүй яриатай хүн шүү.
18. Адилтгасан дүрслэл бүхий өгүүлбэрийг сонгоорой.
 A. Алтай дүүрэн арван түмэн, хонгор бараан адуутай...
 B. Долоон цагаан тохомтой, хөтлийн цагаан дөш хар эмээлтэй...
 C. Гучин алд иштэй, сумт улаан шадтай...
 D. Шүр сайхан дэлтэй, сувд сайхан сүүлтэй...
 E. Бугын тарганыг, булганы харыг намнаж...
19. "Ширнэн гуай **сүүлдээ** манай ажлын газар жижүүр хийдэг болсон юм" гэсэн өгүүлбэрийн онцолсон гишүүний утга, үүргийг зөв тодорхойлсон хэсгийг олоорой.
 A. "манай ажил" гэснийг орны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
 B. "хийдэг болсон юм" гэснийг хугацааны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
 C. "жижүүр" гэснийг орны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
 D. үйлийн эзний утга илэрхийлсэн гол гишүүний үүрэгтэй.
 E. "ажлын газар" гэснийг шинж чанарын утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
20. Нийлмэл үгийн бүтсэн аргыг ажиглаад цэгийн оронд тохирохыг сонгоорой.
 эрх чөлөө, газрын үнэр, арга ухаан, тулганд өрдөх,.....
 A. үгэнд баясах В. хүнээс асуух С. хүрэн үнээ D. улс төр E. насны намар
21. Төрөл биш үгийг олоорой.
 A. туурга B. туувар C. тууварчин D. туугч E. тууварла
22. Үндсэн утгаараа байгаа холбоо үгийг сонгоорой.
 A. нэр хөөдөх B. нэр харах C. нэр зүүх D. нэр хугарах E. нэр өгөх
23. Дуурайх язгуур бүхий үгийг олоорой.
 A. далийх B. хазайх C. шархийх D. муруйх E. сарийх
24. Эдгээр үгэнд бүтээвэр залгаж бичихэд гийгүүлэгч нэмэгдэх үгийг олоорой.
 A. дотно+ы B. Хэрлэн+ий C. төгсөх+ийн D. жолооч+ийн E. зуслан+ийн
25. Бүгдийг зөв бичсэн хэсгийг сонгоорой.
 A. нисч, гэсч, дуусч B. харчхаад, эмээллээ, товчилбол
 C. түүхчдийг, тооцуулашгүй, сарнишгүй D. тэмээчний, нутгийн, нөхцөлөөр
 E. нутгийнханы, харуусаж, нөхөгдшгүй
26. "ᠲᠡᠮᠦᠭᠵᠢᠨ ᠪᠦᠷᠲᠦ ᠲᠡᠭᠦᠷᠦᠭᠦᠨ" гэсэн холбоо үгийг зөв уншаарай.
 A. гүвээний цаана B. гүвээний цана C. хөвөөний зах
 D. хөвгүүний цаана E. ховооны цаана
27. "ой" гэсэн үгэнд харьяалахын тийн ялгалын нөхцөл дагуулсныг олоорой.
 A.  B.  C.  D.  E. 
28. Хатуу дэвсгэрээр төгссөн хэсгийг сонгоорой.
 A.  B.  C.  D.  E. 
29. Тодотгон холбох нөхцөлөөр зөв хувилгасныг олоорой.
 A. B. C. D. E.

- А.
- Б.
- В.
- Г.
- Д.
- Е.

30. Уншаад холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

- A.
- B.
- C.
- D.
- E.

31. Уншаад зөв харгалзуулсан хэсгийг сонгоорой.

- 1.
 - 2.
 - 3.
- a. Австрали
b. автомат
c. автобус

- A. 1c,2a,3 b
- B. 1a,2 b,3c
- C. 1a,2c,3b
- D. 1c,2 b,3a
- E. 1b,2 a,3c

32. "Үгэр түргэн ирэв" өгүүлбэрийн онцолсон үгийг зөв бичсэнийг олоорой.

- A.
- B.
- C.
- D.
- E.

33. "Би отгондоо илүү их хайртай" гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг хэрхэн бичих вэ?

- A.
- B.
- C.
- D.
- E.

34. "ᠮᠣᠩᠭᠣᠯ" гэсэн бичлэгт тохирох үг аль нь вэ?

- A. төмрийн хөрөө
- B. ан гөрөө
- C. хот хүрээ
- D. цан хяруу
- E. хэрээ шувуу

35. Уншихдаа онцолсон үгийн бичлэгийг ажиглаад, бүгдийг зөв бичсэн хэсгийг сонгоорой.

- A.
- B.
- C.
- D.
- E.

- А.
- Б.
- В.
- Г.
- Д.
- Е.

ХОЁР ДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

- 1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг будаарай.
- 2. Зөв харгалзуулсан хариулт бүр нэг оноотой.

2.1. Хэлцийг утгатай нь харгалзуулаарай.

- a. улаан мөндөр буулгах
- b. улаан нүдлэх
- c. улаан эсгий залгихад хүрэх
- d. улаан нүүрээрээ учрах
- e. улаанаар эргэх
- 1. хоол унд хомс
- 2. шунахайрах
- 3. ихэд загнах
- 4. бужигналдаж сүйд болох
- 5. халз уулзах

2.2. "Монголын нууц товчоо" зохиолын эшлэлийг хам сэдэвтэй зөв харгалзуулаарай.

- a. Хулгана жил /1228/ Хэрлэний Хөдөө аралд хурж, Чингис хааны гэрээсэлсэн ёсоор Өгөөдэйг хаан өргөмжлөв.
- b. Хасар, Тататунгааг багш барин, бичиг хууль, цэргийн бодлого тэргүүтэн олон зүйл бичиг заалгаж, удалгүй сурав.
- c. Тэмүүжин өөрөө Бурхан халдун дээр бууж, бүсээ хүзүүндээ эрх мэт өлгөж, малгайгаа гарт сэгэлдэрч, гараараа өвчүүгээ даран, наран өөд хандаж, Бурхан халдунд есөнтөө сөгдөж, өчил өчин, сацал сацав.
- d. "Боорчи баруун гарын түмнийг захирах ноён болов. Мухулай го ван болж зүүн гарын түмнийг захирах ноён болов. Одоо Наяа төв түмнийг захирах ноён болтугай" гэж зарлиг болов.
- e. Сорхоншарын гэрийн тэмдэг нь шөнө турш үүр цайтал сүү самарч, эсэг/айраг/-ээ бүлэх бүлгээ.
- 1. Түүхийн хам сэдэв
- 2. Шашин шүтлэгийн хам сэдэв
- 3. Соёлын хам сэдэв
- 4. Улс төрийн хам сэдэв
- 5. Нийгмийн /ахуй/ хам сэдэв

2.3. Зөвийг нь олж сонгоорой.

		1.	2.	3.
a	Балархай эгшиг гээгдэхгүй үг	нөхөд+ийг	дээдэс+ийг	эрсдэл+ийг
b	"ё"-г шууд залгаж бичих үг	оё+ё	оролц+ё	бод+ё
c	Зөөлний тэмдэг "и" болохгүй үг	барь+мал	ахь+даг	хорь+дог
d	Эр үгэнд "ы" бичих үг	бодомж	навчис	худалч
e	"-г" залгавар залгах үг	хэлтэс	үндсэн	хөгшин

2.4. Дүрс ялган бичих үгсийг тохирох утгатай нь харгалзуулаарай.

- | | |
|---------------------|-----------------|
| a. ᠶᠡᠨᠡᠭ | 1. өрх гэр |
| b. ᠶᠡᠨᠡᠭᠡᠷ | 2. сайныг ерөө |
| c. ᠶᠡᠨᠡᠭᠢᠨ | 3. тоглоом өрөх |
| d. ᠶᠡᠨᠡᠭᠡ | 4. зочны өрөө |
| e. ᠶᠡᠨᠡᠭᠢᠨ | 5. орд өргөө |

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2026 БАГА СУНГАА СОРИЛ

Хувилбар-D

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Эхийн анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг дуустал уншиж ойлгоорой.
3. 1-13 сорилыг эхийн утга санаатай холбож ажиллаарай.
4. Сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.
Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

ХАТАН ЭХИЙН ЗАРЛИГ

Шөнө дундаас хойхно цаг. Өүлэн эх ахлах хэвтүүлийг дуудан ирүүлээд:

“Тэмүүжин, Бөртэ тэргүүтэй хөвгүүд, бэрс, шадар, баатруудыг үтэр цуглуул...” гэж зарлиг айлдахад : Жа ... гээд эргэх гэснээ зогтусаж, “Ахайтан! Их эзнийг дээшлүүлэх гэж үү?” гэвэл өтгөн буурал гэгээгээ задалж суусан хатан ээж: “Тийм ээ! Тэр улсын хаан боловч миний үр учир үгийг дагах ёстой” гэв.

Хатан эхийн зарлигийг сонссон хөвгүүд, бэр, жанжин, хүлэг баатрууд тунгалаг тэнгэрт одод анивчиж, мичид шингэх мөчид эхэд бараалхах ёс жаягаар хувцаслан цуглав.

Толгой гудгар, царай урвагар Өүлэн ээж, зөөлөн зөөлөн алхалсаар ирж түр чимээгүй зогссоноо: “Хамаг Монголын Хаант улсын нэгэн эрхэм чухаг иргэн хорвоогоос халилаа. Иймийн учир, эрчүүл цагаан бөс зүүж, эмс бүсгүйчүүл гэгээгээ задалцгаал!” гэж зарлиг буулгаад: “Эзэн дээдсийн төлөөнөө ёсч шударга, цэгц үнэн журмыг сахихын үлгэрийг үзүүлсэн энэ иргэнийг Хамаг Монголын хаад, ноёд, харц ард хэн боловч мартаж ёсгүй...” гэхэд хамаг эрчүүл, зардсын барьсан цуулмал цагаан бөсийг малгайдаа зүүж, бүсгүйчүүл үсээ задлан унжуулав.

Өүлэн эх баруун ханцуйг үл ялиг хөдөлгөн, цэнхэр пансан алчуур гаргаж, хацар дагасан сувдан нулимсаа арчаад:

“Хаан Тэмүүжин, чи хагацлын үг айлдах уу?” гэв.

Хаантан эхийн зүг мэхэсхийн хүндэтгээд: “Эрэг шороо нурж, энхэл донхол үүсдэг бол иргэн хүн хальж, элэг зүрх эмтрэв. Хоёр сэтгэлт эр хүнийг эр бус эм хэмээлтэй, нэгэн сэтгэлт эмийг, эм бус эр хэмээлтэй гэсэн үг байдаг. Хаан, харц биднээсээ хагацан одсон Хуагчин эмгэн таныгаа баатрын ёсоор хүндлэх учиртай. Та, хаан эцэг Есүхэйн үеэс хатан ээжид минь үнэнч зүтгэж, хайртай Бөртэ хатныг минь бүхээгт тэргэнд нуун, бие сэтгэлээрээ хамгаалж явсан билээ. Хуагчин та, тэр нэгэн цөвүүн өдөр довтлон айсуу дайсныг солонго мэт сонсож, үен мэт үзэж, хатан эхэд минь хэлж, биднийг сэрээгээгүй сэн бол бөөс мэт биес минь Гурван мэргэдийн сумны зэв, сэлэмний ирийг мялаагаад дуусах байсан биш үү! Таны ачаар амьд гарсан бид өсөж өндийж, өрх гэрээ толгойлж, улс үндсээ аварч, өштөнөө өвдөглөж, атаатнаа атгаж, өдий эзрэгт хүрэв. Хаан хэдий хүчтэй ч харцын хүчинд түшнөү гэсэн мэргэн үг буй. Иймийн тул, эмгэн зарц таныгаа бид, түүхэндээ бичиж, түмэндээ сонордуулж явах болно” гэж айлдаад, хойшоо гурав алхахад эмгэний цонхигор нүүрийг гивлүүрээр бүтээв.

Бөөр алаг үхэрт хөллөсөн бүхээгт тэрэг Бунхат уулын зүг хөдөлж, холдон холдсоор үүрийн харанхуйд уусан одлоо.

M. Гүрсэд

1. “Эрчүүл цагаан бөс зүүж, эмс бүсгүйчүүл гэгээгээ задалцгаал!” гэж Өэлүн эх хэлсний учир юу вэ?
A. Эх хатан, хаан хоёрын зөрчил маргаанд домын арга хэрэглэж байсан учраас
B. Хаант улсын чухаг иргэн хорвоогоос хальсан тул гашуудан хүндэтгэх учраас
C. Гурван мэргэд дайран довтлох тул хүн бүр сэрэмж алдахгүй болгох учраас
D. Эрчүүл цагаан бөс зүүж, эмс бүсгүйчүүл гэгээгээ задлах нь шөнө дундын ёс учраас

- E. Шөнө дундаас хойхно ахлах хэвтүүлүүд ямар нэгэн зүйлээс сэрэмж авсан учраас
2. Эхэд өгүүлснээр “мичид шингэх мөч” гэдэг нь аль цаг хугацааг илэрхийлж байна вэ?
A. Хуагчин эмгэн тэртээ цагийн нэг шөнө довтлон ирж буй дайсны чимээг сонссон мөчийг
B. Хамаг Монголын Хаант улсад эрхэм үүрэг гүйцэтгэсэн Хуагчин эмгэний амьсгал хураасан үеийг
C. Хөвгүүд, бэр, жанжин, хүлэг баатрууд Өэлүн эхийн хэлсэн ёс жаягийг дагаж ирсэн хугацааг
D. Бөртэ тэргүүтэй хөвгүүд, бэрс, шадар, баатруудын байнгын ёслол үйлддэг хугацааг
E. Хуагчин эмгэний цогцсыг хөдөөлүүлэхээр авч яваа хугацааг
3. Хүндэтгэлийн үгийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
1. дээшлүүлэх а. ярих, хэлэх
2. сонордуулах b. сэрээх, босгох
3. айлдах c. дуулгах, сонсгох
4. халих d. үхэх, амьгүй болох
A. 1c,2d,3b,4a B. 1a,2b,3c,4d C. 1b,2a,3c,4d D. 1b,2c,3a,4d E. 1d,2b,3a,4c
4. Эхийг сэдвийг сонгоорой.
A. Хатан эхийн зарлигийг хөвгүүд, бэр, жанжин, хүлэг баатрууд дагасан тухай
B. Цэгц шударга, үнэнч зүтгэсэн хүнийг эрхэмлэн хүндэтгэж буй тухай
C. Бөртэ хатныг минь бүхээгт тэргэнд нуун, хамгаалж явсан тухай
D. Чингис хаан Хуагчин эмгэнд зориулан үг хэлж буй тухай
E. Эх хүнийг төрт ёсны дагуу хүндэтгэн хайрлаж хамгаалах тухай
5. Эхийн гол санааг илэрхийлэх хэлцийг сонгоорой.
A. Хэлүүлж явах нэр, хэвтэж хоцрох яс
B. Төрийн нуруу төвшин бол түмний нуруу амгалан
C. Эвдрэх төрийн ноён байснаас энх төрийн боол байсан нь дээр
D. Шулуун явдлын гэгээн нь, шударга төрийн хүндлэл нь
E. Хаан гэгч улсдаа эзэн, харуул гэгч ордондоо эзэн
6. Эхийн үйл явдал өрнөж эхлэх шалтгаан юу вэ?
A. Хойшоо гурав алхахад эмгэний цонхигор нүүрийг гивлүүрээр бүтээв.
B. “Тэмүүжин, Бөртэ тэргүүтэй хөвгүүд, бэрс, шадар, баатруудыг үтэр цуглуул...” гэж зарлиг айлдав.
C. Хоёр сэтгэлт эр хүнийг, эр бус эм хэмээлтэй, нэгэн сэтгэлт эмийг, эм бус эр хэмээлтэй гэсэн үг байдаг.
D. Хамаг эрчүүл, зардсын барьсан цуулмал цагаан бөсийг малгайдаа зүүж, бүсгүйчүүл үсээ задлан унжуулав.
E. Бөөр алаг үхэрт хөллөсөн бүхээгт тэрэг Бунхат уулын зүг хөдөлж, холдон холдсоор үүрийн харанхуйд уусан одлоо.
7. “Иймийн тул, эмгэн зарц таныгаа бид, түүхэндээ бичиж, түмэндээ сонордуулж явах болно” онцолсон холбох үгийг ямар үүргээр хэрэглэсэн байна вэ?
A. Үйлийн орны адил төсийг тогтоох
B. Мэдээллийг хооронд нь жиших харьцуулах
C. Өмнөх мэдээллээс дараагийн мэдээллийг ялган онцлох
D. Өмнөх мэдээллүүдийг ерөнхийлөн дүгнэх
E. Мэдлээлд хоорондын шалтгаан-үрийг тодруулах
8. Их хаан, Хуагчин эмгэний үнэнч шударга зүтгэлийг хэрхэн үнэлж дүгнэсэн бэ?
A. Эрэг шороо нурж, энхэл донхол үүсдэг бол иргэн хүн хальж, элэг зүрх эмтрэв.
B. Энэ иргэнийг хамаг монголын хаад, ноёд, харц ард хэн боловч мартаж ёсгүй...
C. Хаан, харц биднээсээ хагацан одсон Хуагчин эмгэн таныгаа баатрын ёсоор хүндлэх учиртай.

- D. Хоёр сэтгэлт эр хүнийг, эр бус эм хэмээлтэй, нэгэн сэтгэлт эмийг, эм бус эр хэмээлтэй гэсэн үг байдаг.
E. Таны ачаар амьд гарсан бид өсөж өндийж, өрх гэрээ толгойлж, улс үндсээ аварч естнөө өвдөглөж, атаатнаа атгаж өдий зэрэгт хүрэв.
9. "Бөөр алаг үхэрт хөллөсөн бүхээгт тэрэг Бунхат уулын зүг хөдөлж, холдон холдсоор үүрийн харанхуйд уусан одлоо" гэсэн хэсгээс үйл явдлын хувирал өөрчлөлтийг дүрслэхэд чухал үүрэгтэй үг хэллэгийг олоорой.
A. хөллөх, хөдлөх, холдох, уусан одох
B. үхэрт хөллөсөн, бүхээгт тэрэг хөдлөх
C. бөөр алаг, үүрийн харанхуй
D. бүхээгт тэрэг, харанхуйд уусах
E. Бунхат уулын зүг, холдон холдох
10. "Тэр нэгэн цөвүүн өдөр довтлон айсуй дайсныг **солонго мэт** сонсож, **үен мэт** үзэв" гэсэн өгүүлбэрийн онцолсон дүрслэлийг олоорой.
A. егөөдөл B. амьдчилал C. адилтгал D. багасгал E. бэлгэдэл
11. "Хуагчин эмгэн Бөртэ хатныг минь бүхээгт тэргэнд нуун **бие сэтгэлээрээ хамгаалж явсан билээ**" өгүүлбэрийн онцолсон үгийг хэлцээр солин найруулбал аль нь тохирохгүй вэ?
A. зүрх гаргах B. хоёргүй сэтгэлээр C. амь тавин зүтгэх
D. хар толгойгоо бодох E. амиа хайрлахгүй
12. Хуагчины "Эрхэм чухаг иргэн" болох шинжийг тодруулах үүргээр орсон бүлэг үгс аль вэ?
A. Өзлүн эх, Тэмүүжин, Бөртэ, хөвгүүд, бэрс, шадар баатрууд, ахлах хэвтүүл, зардас, хаад ноёд, харц, хамаг эрчүүл
B. ёсч шударга, цэгц үнэнч, нэгэн сэтгэлт, үнэнч зүтгэлт, бие сэтгэлээрээ, солонго мэт сонсдог, үен мэт үздэг
C. үтэр цуглуулах, эхэд бараалхах, хорвоогоос халих, гэгээ задлах, зүрх эмтрэх, хагацан одох, айлдах, түмэндээ сонордуулах, мэхэсхийн хүндэтгэх
D. гудгар, урвагар, тунгалаг, өтгөн буурал, цуулмал, цагаан, цөвүүн, солонго мэт, үен мэт, цонхигор, бөөр алаг
E. шөнө дунд, мичид шингэх мөч, тэр нэгэн цөвүүн өдөр, үүрийн харанхуй
13. "Эзэн дээдсийн төлөөнөө ёсч шударга, цэгц үнэн журмыг сахихын үлгэрийг үзүүлсэн энэ иргэнийг Хамаг Монголын хаад, ноёд, харц ард хэн боловч мартаж ёсгүй" гэсэн хэсэгт ямар өнгө аяс илэрч байна вэ?
A. хөөрхийлсэн B. тайтгарсан C. цэцэрхсэн D. сануулсан E. санааширсан
14. "Гэвч... чи, Тэмүүжин хүүг минь баахан мартсан мэт" гэсэн өгүүлбэрт цуваа цэг хэрэглэсний учир юу вэ?
A. Мэгдэж түгдэрсэн тул цуваа цэг хэрэглэсэн.
B. Үг, өгүүлбэр төгссөн боловч зохиогч санаагаа бүрэн гаргаж чадаагүй дутуу орхисон тул цуваа цэг хэрэглэсэн.
C. Өгүүлбэрийн дунд хэлэлгүй орхисон үгийн оронд цуваа цэг хэрэглэсэн.
D. Эш татсан зүйлийн энд тэндээс орхисон тул цуваа цэг хэрэглэсэн.
E. Зохиолын том бүлэг, их хэсгийг орхисон тул мөргөсөн цэг хэрэглэсэн.
15. Эсрэг утгатай үг бүхий хэлцийг сонгоорой.
A. Бохирыг нь арилгаж, борвийг нь тэнийлгэх
B. Навч цэцэг нарнаас, насны жаргал ажлаас
C. Наадаж явбал насны жаргал, инээж явбал өдрийн жаргал
D. Данх руугаа толгойгоо хийсэн, тогоо руугаа хошуугаа хийсэн
E. Маңдахад үүдээр багтахгүй, муудахад үүдээр гарахгүй
16. Дээд найруулгын зэрэг бүхий өгүүлбэрийн сонгоорой.
A. Туурга нэвт туяатай, гэр нэвт гэгээтэй.
B. Нарт тэнгэрийн дор насад энх амьдарна.
C. Нарны гэрэл тооноор тусаж, гэрт гэгээ нэмнэ.
D. Мэргэд гэдэг бол нар сарыг хамтатгасан хурмаст гэвээс болно
E. Нар шиг мандаж, сар шиг гэрэлтэнэ.
17. "-ын, -ийн -ий,-ы" бүтээвэр нь зориулалтын утга ялгаж байгаа хэсгийг олоорой.
A. нүдний шил, шүдний сойз B. газрын хол, усны урт
C. уулын чулуу, усны эх D. сарын сайн нь, өдрийн сайхан нь
E. миний ном, чиний цүнх
18. Ихэсгэж хэтрүүлсэн дүрслэл бүхий өгүүлбэрийг сонгоорой.
A. Туг сайхан сүүлтэй, тугал хар нүдтэй...
B. Туулай сайхан зоотой, дугариг сайхан хүзүүтэй...
C. Ерэн алд биетэй, есөн төө чихтэй...
D. Ан шувуундаа унадаг их хар морьтой...
E. Хас эрдэнэ шүдтэй, халир мөнгөн уруултай...
19. "Баатар ах **анхандаа** миний хичээлийн хуваарийг ялгаж өгдөг байв" гэсэн өгүүлбэрийн онцолсон гишүүний утга, үүргийг зөв тодорхойлсон хэсгийг олоорой.
A. "өгдөг байв" гэснийг орны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
B. "хуваарийг" гэснийг цагийн утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
C. "ялгаж өгдөг байв" гэснийг хугацааны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
D. "хичээл" гэснийг тодотгож, дэлгэрүүлэх үүрэгтэй.
E. "Баатар ах" гэснийг шинж чанарын утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
20. Нийлмэл үгийн бүтсэн аргыг ажиглаад цэгийн оронд тохирохыг сонгоорой.
Аз жаргал, төмөр зам, эрч хүч, туулайн бөөр,.....
A. эрүү толгой B. ган зам C. модон байшин D. цэцгийн дэлбээ E. санааны чимэг
21. Төрөл биш үгийг олоорой.
A. буурь B. буудай C. буудал D. буулт E. буулгалт
22. Үндсэн утгаараа байгаа холбоо үг аль нь вэ?
A. морь алдах B. сэтгэл алдах C. нүд алдах D. шүүрс алдах E. ам алдах
23. Дүрслэх язгуур бүхий үгийг олоорой.
A. пасхий B. хархий C. түсхий D. торхий E. гэдий
24. Эдгээр үгэнд бүтээвэр залгаж бичихэд гийгүүлэгч нэмэгдэх үгийг олоорой.
A. орон+ы B. байшин+ийн C. дуусах+ын D. ээлж+ийн E. гадна+ы
25. Бүгдийг зөв бичсэн хэсгийг сонгоорой.
A. дуусч, тосч, харуусч B. тарьчих, өгчхүүзэй, жимийлций
C. саначхаад, буудаллаа, хэлбэл D. тогтчоод, саначихыг, мартчихангуут
E. больчихыг, болчхоод, ороочхонгуут
26. "ᠮᠣᠩᠭᠣᠯ" гэсэн холбоо үгийг зөв уншаарай.
A. атаачны хүү B. адуучны гүү C. адуучны хүү D. атаачны хөө E. адуучны хөө
27. "тараг" гэсэн үгэнд үйлдэхийн тийн ялгалын нөхцөлийг зөв дагуулсан хэсгийг олоорой.
A. B. C. D. E.
28. Зөөлөн дэвсгэрээр төгссөн хэсгийг сонгоорой.
A. B. C. D. E.

- А. Өмнө
- Б. Дунд
- В. Зүүн
- Г. Баруун
- Д. Зүүн-дунд
- Е. Зүүн-баруун

29. "саар" нөхцөл залгахад холбох эгшгийн дүрмээр бичигдэх үгс нь аль вэ?

- A. Өмнө
- B. Дунд
- C. Зүүн
- D. Баруун
- E. Зүүн-дунд

30. Уншаад холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

- A. Өмнө
- B. Дунд
- C. Зүүн
- D. Баруун
- E. Зүүн-дунд

31. Уншаад зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

- 1. Өмнө
 - 2. Дунд
 - 3. Зүүн
- a.Австри
b.автономи
c.автомат

- A. 1b,2 a,3c B. 1a,2 b,3c C. 1a,2c,3b D. 1c,2a,3 b E. 1b,2c,3a

32. "Гэв гэнэт хашгирав" өгүүлбэрийн онцолсон үгийг зөв бичсэнгийг олоорой.

- A. Өмнө
- B. Дунд
- C. Зүүн
- D. Баруун
- E. Зүүн-дунд

33. "Тэр одоохондоо унаа аваагүй" гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг хэрхэн бичих вэ?

- A. Өмнө
- B. Дунд
- C. Зүүн
- D. Баруун
- E. Зүүн-дунд

34. "Ахуй" гэсэн бичлэгт тохирох үг аль нь вэ?

- A. хурга ишиг B. хороох цөөлөх C. ахмадын хороо
D. гар хуруу E. адуу хураа

35. Уншихдаа онцолсон үгийн бичлэгийг ажиглаад бүгдийг зөв бичсэн хэсгийг сонгоорой.

- A. B. C. D. E.

- Өмнө
- Дунд
- Зүүн
- Баруун
- Зүүн-дунд
- Зүүн-баруун

ХОЁР ДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

- Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг будаарай.
- Зөв харгалзуулсан хариулт бүр нэг оноотой.

2.1.Хэлцийг утгатай нь харгалзуулаарай.

- | | |
|---------------------------------|--------------------|
| a. Өрөмний өт шиг | 1. ихэд санаархах |
| b. Бой нь арилж борви нь тэнийх | 2. хоосон мөрөөдөх |
| c. Дотор нь ороод гарсан юм шиг | 3. сайн мэдэх |
| d. Зангуу тариад эсгий хийх | 4. тогтворгүй |
| e. Оготнын дуу тэнгэрт хүрэхгүй | 5. том болох |

2.2. "Монголын нууц товчоо" зохиолын эшлэлийг хам сэдэвтэй зөв харгалзуулаарай.

- | | |
|--|------------------------------|
| a. Барс жил /1206/ Онон мөрний эхэнд хуралдаж, есөн хөлт цагаан тугаа мандуулаад, Тэмүүжинд Чингис хаан /Далай хаан/ цолыг өгөв. | 1. Шашин шүтлэгийн хам сэдэв |
| b. Мэргидийн нутаг дээр булган малгайтай, бугын арьсан гуталтай, булган хөөмий дээлтэй Хүчү гэдэг нэртэй, таван настай хөвүүн хоцорсныг олов. | 2. Соёлын хам сэдэв |
| c. Тэр цагт Чингис хаан, тэнгэр эцэгтээ мөргөө гэж довцог өндөр дээр гарч, тохмоо дэлгэж тавиад, бүсээ хүзүүндээ өлгөж залбиран өчив. | 3. Түүхийн хам сэдэв |
| d. Улсыг байгуулахад зүтгэсэн хүмүүсийг түмний ноёд, мянганы ноёд, зууны ноёд, аравны ноёд болгож, соёрхлыг өгөх хүмүүст өгч зарлиг буулгав. | 4. Нийгмийн /ахуй/ хам сэдэв |
| e. "Алаг сайхан хоньдыг ар дүүрэн бэлчээж, хонин олон сүргийг хот дүүрэн өсгөж, шимтэй шөлийг бэлтгэж явья" гэсэн тул Дэгэйгээр хонь адуулгав. | 5. Улс төрийн хам сэдэв |

2.3.Зөвийг нь олж сонгоорой.

	1.	2.	3.
--	----	----	----

a	Эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэх үг	баялаг+ийг	хүчтэн+ээс	туулчих+аар
b	"я"-г шууд залгаж бичих үг	уралд+я	хамгаал+я	уя+я
c	Зөөлний тэмдэг "и" болохгүй үг	тарь+мал	шаагь+ж	тахь+саар
d	Эр үгэнд "ий" бичих үг	жудаг	дамжлага	ангир
e	"-л" залгавар залгахад хойноо эгшигтэй бичих үг	данс	харш	жүжиг

2.4. Дүрс ялган бичих үгсийг тохирох утгатай нь харгалзуулаарай.

- | | |
|---------|--------------|
| a. ᠋ᠨᠪᠣ | 1. очно гэв |
| b. ᠋ᠨᠪᠢ | 2. гэв гэнэт |
| c. ᠋ᠨᠪᠡ | 3. ид хав |
| d. ᠋ᠨᠪᠠ | 4. дээл хав |
| e. ᠋ᠨᠪᠣ | 5. хав хатуу |

C			D	
№	Зөв хариу	Оноо	Зөв хариу	Оноо
1	D	2	B	2
2	E	2	C	2
3	C	2	D	2
4	A	2	B	2
5	E	2	D	2
6	B	2	B	2
7	C	2	E	2
8	D	2	E	2
9	C	2	A	2
10	D	2	C	2
11	C	2	D	2
12	E	2	B	2
13	C	2	D	2
14	E	2	C	2
15	D	2	E	2
16	B	2	D	2
17	C	2	A	2
18	D	2	C	2
19	B	2	C	2
20	D	2	A	2
21	A	2	B	2
22	E	2	A	2
23	C	2	E	2
24	E	2	B	2
25	D	2	E	2
26	A	2	C	2
27	D	2	A	2
28	C	2	D	2
29	E	2	A	2
30	B	2	A	2
31	D	2	E	2
32	E	2	D	2
33	B	2	E	2
34	A	2	D	2
35	B	2	E	2

2.1	a	3	1	a	4	1
	b	2	1	b	5	1
	c	1	1	c	3	1
	d	5	1	d	2	1
	e	4	1	e	1	1
2.2	a	1	1	a	3	1
	b	5	1	b	2	1
	c	2	1	c	1	1
	d	4	1	d	5	1
	e	3	1	e	4	1
2.3	a	3	1	a	1	1
	b	1	1	b	3	1
	c	3	1	c	2	1
	d	2	1	d	1	1
	e	1	1	e	3	1
2.4	a	2	1	a	4	1
	b	4	1	b	5	1
	c	5	1	c	3	1
	d	1	1	d	2	1
	e	3	1	e	1	1